

**ЛУУС СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН АЛБАН ХААГЧДЫН  
2023 ОНЫ СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ**

2023 оны 12 дугаар сарын 06

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Төсөв	Суурь түвшин	Хүрэх үр дүн	Хугацаа	Хэрэгжилт	Хувь
<b>Албан хаагчдыг мэргэшүүлэх чиглэлээр зохион байгуулах сургалт</b>								
1.	Удирдах ажилтны сургалтад хамрагдах	Сургалтын тоо	Улсын төсвөөс 1 сая төг	4	4	1-4 улирал	Сумын Засаг дарга 5 удаа, Засаг даргын орлогч 4 удаа, Засаг даргын Тамгын газрын дарга 6 удаа, , Багийн засаг дарга нар 3 удаагийн сургалт, зөвлөгөөнд оролцож 896,000 төгрөгийн томилолт, шатахуунд 373,500 төгрөг олгосон байна.	100
2	Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулагддаг онлайн сургалтад хамрагдах	Хамрагдсан албан хаагчдын тоо	-	10	13	7 хоног бүрийн пүрэв гаригт	Долоо хоног бүрийн 4:7:10 сургалтад 11 албан хаагч 19 удаагийн сургалтад хамрагдлаа.	100
4.	Удирдлагын академийн мэргэшүүлэх дунд болон богино хугацааны сургалтад хамруулах	Хамрагдсан сургалт, албан хаагчдын тоо	-	2	2	2-4 улирал	Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 1 албан хаагч, төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг мэргэшүүлэх богино хугацааны сургалтад 1 албан хаагч тус тус хамрагдаж төгссөн.	100
5.	Хувь хүний хөгжлийн сургалтад албан хаагчдыг хамруулах	Сургалтын тоо, хамрагдсан хүний тоо	УТ 2 сая	1	1	2-3 улиралд	Сайнцагаан сумаас сургагч багш Мөнхтуяаг урьж ЗДТГ-ын ажилчид болон бусад байгууллагын үйлчилгээний албан хаагчид, нийт 40 төрийн албан хаагчийг оролцуулан Байгууллагын соёл, ёс зүйн талаарх 2 цагийн сургалтыг авлаа. Уг сургалт нь хувь хүн рүүгээ илүү чиглэсэн, өгөөжтэй сургалт боллоо. Сургалтын зардалд 300,000 төгрөг зарцуулсан.	100
6.	Албан хаагчдыг аймаг болон бусад газраас зохион байгуулсан сургалтад	Сургалтын тоо Хамрагдсан	УТ 500.000 төг	10	10	1-4-р улирал	Улс, аймаг, орон нутгаас зохион байгуулагдсан 26 удаагийн танхимын, 53 удаагийн цахим сургалтад	100

	хамруулах	албан хаагчдын тоо					давхардсан тоогоор 53 албан хаагч хамрагдаж 2,894,000 төгрөгийн томилолтын зардал, 792,100 төгрөгийн шатахууны зардал тус тус олгосон байна.	
7.	Шинээр мөрдөгдөж байгаа хуулийн сургалт зохион байгуулах, хамруулах	Сургалтын тоо Хамрагдсан албан хаагчдын тоо		2	4	1-4-р улирал	Хууль эрх зүйн мэргэжилтэн 2023 оны 06 дугаар сард томилогдсон бөгөөд томилогдсоноос хойш ЗДТГ-ын албан хаагчид болон бусад төрийн байгууллагын албан хаагч, иргэдэд давхардсан тоогоор 28 удаагийн сургалтаар 246 орчим иргэдэд 6 төрлийн хуулийн анхан шатны мэдлэг олгосон.	100
8.	Монгол бичгийн анхан болон дунд шатны сургалтын дутуу хичээлийг нөхөн үзэж, судлах	Судалсан албан хаагчдын тоо	-	5	8	2-3-р улирал	Монгол бичгийн анхан болон дунд шатны 24 цагийн модуль сургалтад батламж аваагүй 8 албан хаагчийг Хэлний бодлогын зөвлөл, Насан туршийн боловсрол хамтран зохион байгуулсан сургалтад бүрэн хамруулсан.	100
9.	Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем ер.е-mongolia.mn ашиглалтыг сайжруулах	Ашиглалтын хувь	УТ 500.000 төг	60	70	2-4-р улирал	ер.е-mongolia.mn системд төрийн байгууллагууд албан хаагчдыг бүртгэн ашигладаг. ЗДТГ нь 19 албан хаагч бүртгэлтэйгээс 16 албан хаагч буюу 84.2 хувь нь ер.е-mongolia.mn системийг тогтмол ашиглаж байна. Хариуцсан албан хаагч 2 удаа томилолтоор ажиллаж 56,000 төгрөг олгосон.	100
10.	“Эрх зүйн хөтөч”-ийн сургалтад албан хаагчдыг хамруулах, мэдээлэл түгээх	Сургалтын тоо, хүргэсэн мэдээллийн тоо	УТ 200.000 төг	4	4	2-4-р улирал	Сумын эрх зүйн хөтчүүд 1 удаагийн тахимын сургалтад 1 албан хаагч, цахимаар 1 удаагийн багц сургалтад 5 албан хаагч хамрагдсан. Цахимаар 8 удаагийн мэдээллийг иргэдэд хүргэж 598 хандалт авсан байна.	100
11.	Төрийн болон орон нутгийн өмчийн харилцааны сургалт	Зохион байгуулсан сургалтын тоо Хамрагдсан	-	0	1/15	2-3 р улирал	2023 оны 09 дүгээр сарын 25-ний өдөр аймгийн ОНӨГ-аас орон нутгийн өмчийн эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт	100

		хүний тоо					шалгалт хийх, зөвлөн туслах удирдамжийн дагуу 2022 оны өмч эзэмшүүлэх гэрээ дүгнэх, байгууллагуудын өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагаанд хяналт хийж Төрийн болон Орон нутгийн өмчийн тухай хуулийн талаар бүх байгууллагын дарга, нягтлан, нярав, өмч хамгаалах зөвлөлийн нийт 33 хүнд сургалт хийсэн.	
12.	ТАХ-ийн ёс зүйг дээшлүүлэх чиглэлийн сургалт	Хамрагдсан хүний тоо	100,000	-	13	2-4-р улирал	Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн сургалтыг Хууль эрх зүйн мэргэжилтэн хариуцан зохион байгуулж 5 байгууллагын 80 албан хаагчийг хамруулсан. Сайнцагаан сумаас сургагч багш Мөнхтуяаг урьж хувь хүний ёс зүй, харилцаа, хандлага чиглэлээр 40 төрийн албан хаагч сургалтад хамрагдлаа. 120 дугаар сарын 13-ний өдөр төрийн албан хаагчдын нэгдсэн зөвлөгөөн	100
13.	Хөдөлмөрийн харилцаан дахь хүний эрхийн чиглэлийн сургалт	Хамрагдсан хүний тоо	250,000	-	65	2-4 улирал	Хөдөлмөрийн тухай хуулийн 6 дугаар бүлэг (Ажил амралтын цаг), 7 дугаар бүлэг (Цалин хөлс, олговор) сэдвээр 59 хүнд сургалт зохион байгуулсан. Гурван багийн ИНХ-д туслах малчны гэрээний эрх зүйн зохицуулалт ач холбогдлоор 377 иргэнд сургалт мэдээлэл хүргэсэн.	100
14.	Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулагдсан сургалтад хамрагдах	Хамрагдсан сургалтын тоо	-	2	2	2-4-р улирал	Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан 2 удаагийн цахим сургалтад 12 албан хаагч хамрагдсан. Шинээр томилогдсон албан хаагчид мэдлэг олгох сургалтад эрүүл мэндийн төвийн даргын хамт хамрагдсан. Авлигын эсрэг ОУ-ын өдрийг угтан Авлига, ашиг сонирхлын зөрчил ба эрүүгийн хариуцлага сэдвээр төрийн албан хаагчдад, Авлига ба түүний шалтгаан нөхцөл сэдвээр 7-9 ангийн 39	100

							суралцагчдад, төрийн байгууллагуудын 38 албан хаагчид сургалт хийсэн. Нийт хамрагдсан хүн: 91	
15.	Архив, албан хэрэг хөтлөлтийн талаар албан хаагчидад сургалт хийх	Сургалтын тоо, хамрагдсан албан хаагчдын тоо	-	1	1/13	2-4-р улиралд	Архив, бичиг хэргийн ажилтныг Архивын ерөнхий газраас жил бүр зохион байгуулагддаг “Архив албан хэрэг хөтлөлтийн ажилтныг мэргэшүүлэх” анхан шатны 30 хоногийн сургалтад төлбөрийг байгууллагаас бүрэн хариуцан мэргэшүүлсэн. Аймгийн Архивын тасаг, архивчдын хөгжил сургалтын төвтэй хамтарсан 40 цагийн мэргэшүүлэх сертификаттай сургалтад 2023 оны 10 дугаар сарын 25-26-ний өдрүүдэд хамрагдсан. Дээрх сургалтуудад заагдсан мэдээллээр Хүүхдийн цэцэрлэг, Соёлын төв болон өөрийн байгууллагын нийт 17 хүнд арга зүйн зөвлөгөө, зөвлөмжийг өгч ажилласан. Мэргэшүүлэх зардалд 306,000 төгрөгийг байгууллагын төсвөөс зарцуулсан	100
16.	Dundgovi.gov.mn сайтад мэдээлэл хэрхэн байршуулах талаар төрийн байгууллагуудад мэдээлэл хүргэх	Мэдээллийн тоо	-	1	2	1-3-р улирал	Мэдээллийн ил тод байдал, Luus.du.gov.mn сайтад хэрхэн мэдээлэл оруулах талаарх АЗДТГ-аас зохион байгуулагдсан 4 удаагийн сургалтад хамрагдаж дотоод ажил хариуцсан мэргэжилтэн мэдлэгээ сайжруулсан. Төрийн байгууллагуудын мэдээ мэдээллийг тухай бүр суманд олгосон 1 админы эрхээр оруулж байна. Төрийн байгууллагуудын дарга, эрхлэгч нарт Luus.du.gov.mn сайтад мэдээ мэдээллийг хэрхэн оруулах, ямар шаардлага хангаж мэдээллээ бэлтгэн ирүүлэх зэргээр шуурхай хуралдаанд оролцогчдод 1 удаа, байгууллагуудын мэдээлэл боловсруулдаг ажилтнуудад	100

							1 удаа тус тус мэдээллийг хүргэсэн.	
Хэрэгжилтийн дундаж хувь: Зарцуулсан төсөв: 5,456,600 төгрөг								100

ХЭРЭГЖИЛТ ГАРГАСАН:  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

Б.ГАНЧИМЭГ